

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2018 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	2
2	Аудитын тайлан.....	4
2.1	Оршил.....	4
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	5
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	6
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	6
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	6
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	7
2.8.1	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	7
2.8.1.1	Санхүүгийн тайлан бэлтгэхтэй холбоотой асуудал	7
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	7
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	8
2.11	Шилэн дансны мэдээлэл	8
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	8
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	8
3	МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ	10
4	АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН	13
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	13
4.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	14
4.3	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	16
4.4	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	18
4.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	19
5	Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	21

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
АДБОУС	Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
116 ДУГААР СУРГУУЛИЙН ДАРГЫН
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ С.ЭНХТУЯА
ТАНАА

2019.02.25 № 06/306
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйл, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Ерөнхий боловсролын 116 дугаар сургуулийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Ерөнхий боловсролын 116 дугаар сургуулийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Ерөнхий боловсролын 116 дугаар сургуулийн 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Аудитын гол асуудал

Ажилчдад олгохоор төсөвт тусгагдсан 2018 оны 4 дүгээр улирлын олгогдоогүй үр дүнгийн урамшуулал 23,428.2 мянган төгрөгийг санхүүгийн тайланд өр үүсгэж тайлагнаагүй зөрчил нь санхүүгийн тайлангийн үнэн зөв байх болон иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2 Аудитын тайлан

2.1 Оршил

Ерөнхий боловсролын 116 дугаар сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Ерөнхий боловсролын 116 дугаар сургуулийн даргын үүрэг гүйцэтгэгч С.Энхтуяа танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ерөнхий боловсролын 116 дугаар сургуулийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Ерөнхий боловсролын 116 дугаар сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 02 дугаар сарын 11-нээс 2019 оны 02 дугаар сарын 18-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 02 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, “Их Наяд Аудит” ХХК-ийн чанарын хяналтын менежер Х.Ариунзул, ахлах аудитор Л.Сайзмаа нар чанарын хяналтыг гүйцэтгэн, аудитор М.Мөнхзул, аудиторын туслах С.Бямбацэцэг нар аудитыг хариуцаж хэрэгжүүлэв.

Ерөнхий боловсролын 116 дугаар сургууль 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Санхүүгийн аудитын газарт 2019 оны 02 дугаар сарын 11-ний өдөр 22 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБООУС, АООУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНБООУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Ерөнхий боловсролын 116 дугаар сургуулийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Ерөнхий боловсролын 116 дугаар сургууль нь “Харааны бэрхшээлтэй хүүхдүүдэд үзүүлж буй боловсролын үйлчилгээг чанаржуулж, суралцагчдыг бодит чадвартай иргэн болгон төлөвшүүлэхэд оршино” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилгоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Монгол Улсын Боловсрол, Соёл, Шинжлэх Ухааны сайдын 2007 оны 161 дүгээр тушаалд Ерөнхий боловсролын 116 дугаар сургуулийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хүүхдийн тусгай хэрэгцээт боловсрол олгох үйл ажиллагаа

Ерөнхий боловсролын 116 дугаар сургуулийн үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Ерөнхий боловсролын 116 дугаар сургуулийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНБООУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хууль
- Хувь хүний орлогын албан татварын тухай хууль
- Боловсролын тухай хууль
- Бага, дунд боловсролын тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

- Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 24 дүгээр зүйл Албан татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх, 24.1 Цалинд ногдох жилийн албан татварын хөнгөлөлтийн хувь хэмжээний өөрчлөлт

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Ерөнхий боловсролын 116 дугаар сургуулийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Ерөнхий боловсролын 116 дугаар сургууль санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Axplorer” програм хангамж ашигладаг байна.

Ерөнхий боловсролын 116 дугаар сургуулийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй гэж үзлээ.

2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Ерөнхий боловсролын 116 дугаар сургуулийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 11 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 5 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1 хувиар сонгов.

Аудитыг төлөвлөх үе шатанд нийт хөрөнгийг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон боловч гүйцэтгэх үе шатанд нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгон өөрчилсөн нь тус сургууль улсын төсвөөр санхүүждэг тул санхүүжилтийн зарцуулалт

төлөвлөлтөөс хэтрэх, үр ашиггүй зардал гаргах зэрэг эрсдэлд өртөмтгий байх магадлалыг харгалзан үзэн нийт зардлыг суурь болгон авах нь зүйтэй гэж үзсэнтэй холбоотой юм.

Ерөнхий боловсролын 116 дугаар сургуулийн 2018 оны нийт зардал 991,783.0 мянган төгрөг бөгөөд түүний 1 хувь болох 9,917.8 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1 хувиар тооцсон нь уламжлалт болон хяналтын эрсдлийг дунд гэж үнэлсэнтэй холбоотойгоор материаллаг түвшинг дунджаар тогтоосон.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 5 чиглэлээр аудитын 12 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 6 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 5 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 1 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

/мянган төгрөгөөр/

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	5	28,471.9	
2	Албан шаардлага өгсөн	1		
	Дүн	6	28,471.9	

2.8.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

2.8.1.1 Санхүүгийн тайланг бэлтгэхтэй холбоотой асуудал

Санхүүгийн тайланг Төсвийн тухай хуулийн цаглабарт багтаан гаргаагүй, 2019 оны 02 дугаар сарын 11-нд Төрийн аудитын байгууллагад хүргүүлсэн.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1, 16 дугаар зүйлийн 16.5.7 дахь заалтыг тус тус зөрчсөн.

Шийдвэрлэсэн: Албан шаардлага хүргүүлсэн.

2.9 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

- Тухайн аудитын хамрах хүрээний асуудал боловч цаг хугацааны хязгаарлагдмал байдал болон тус сургуулийн нярав өвчний улмаас шалтгаалан ажилдаа ирэхгүй, тооллогын бүртгэлийг гаргаж өгөөгүй байдлаас бараа материалын түүвэрчилсэн

тооллого хийгээгүй, хөрөнгөтэй холбоотой эрсдэл байж болох тул 2019 онд хөрөнгийн түүвэрчилсэн тооллого хийх.

- 2018 оны 9, 10 дугаар саруудын батлагдсан цалингийн сүлжээний шатлалын дагуу нэмэгдсэн үндсэн цалингийн зөрүүг 2019 оны төсвийн тодотголоор нэмж суулган батлуулсан эсэхийг анхаарч авч үзэх.
- Цалингийн тооцооны хүснэгтийг санхүүгийн програмтай уялдуулан сайжруулж, цалингийн журналын бичилт нь зөв тусгагдсан эсэхийг шалгаж үзэх.

2.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Ерөнхий боловсролын 116 дугаар сургуулийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй холбоотой 12 хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд улсын төсвөөс 868,442.7 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтаас 12,651.2 мянган төгрөг, нийт 881,093.9 мянган төгрөгийн санхүүжилт авсан байна. Гүйцэтгэлээр төсвийн урсгал үйл ажиллагааны зардал 865,243.4 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтийн зардал 12,649.9 мянган төгрөг, нийт 877,893.3 мянган төгрөг зарцуулж, төсвийн үлдэгдэл 3,200.6 мянган төгрөгийн үлдэгдлийг төсөвт буцаан төвлөрүүлжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 865,243.4 мянган төгрөг буюу 99.6 хувьтай байгаа нь хоол хүнсний нормативт зардлыг 1.3 хувиар хэтрүүлсэн боловч байр ашиглалтын болон хангамж, бараа материалын зардлуудыг дутуу зарцуулсантай холбоотой.

2.11 Шилэн дансны мэдээлэл

Ерөнхий боловсролын 116 дугаар сургууль Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны тухай хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянан үзэхэд 2018 оны сурагчдын амралтын 6-8 сараас бусад саруудад нийт санхүүжилтийн орлого, цалингаас бусад таван сая төгрөгнөөс дээш томоохон зардлууд болох НДШ, цахилгаан, хоол, урсгал засвар зэрэг зардлуудын мэдээллийг байршуулжээ.

2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар амралтын цалинг зөв тооцох тухай нэг зөвлөмж өгснийг 2018 оны жилийн эцсийн байдлаар 100 хувьтай хэрэгжүүлсэн байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Ерөнхий боловсролын 116 дугаар сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Ерөнхий боловсролын 116 дугаар сургуулийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл

тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Ерөнхий боловсролын 116 дугаар сургуулийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв.

1. Балансын данстай холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт:

Ажилчдад олгохоор 2018 оны төсөвт батлагдсан 4 дүгээр улирлын олгогдоогүй үр дүнгийн урамшуулал 23,428.2 мянган төгрөгийг санхүү байдлын тайланд өр үүсгэж тусгаагүй.

Энэ нь үнэн зөв байх болон үнэлгээ, иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хууль 26 дугаар зүйлийн 26.1 “Төсвийн байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу бүрэн аккрузал суурьтай нягтлан бодох бүртгэл хөтөлнө”, 26.2 “Төсвийн бүртгэлийг тохируулсан аккрузал сууриар бүртгэж, тайлагнана” заалтыг тус тус зөрчсөн байна.

1.2 Эрсдэл:

- Санхүүгийн байдлын тайлан, санхүүгийн үр дүнгийн тайлан тус тус буруу илэрхийлэгдсэн байх
- Цалин хөлсийг буруу тогтоосон байх

1.3 Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1, 26.2 заалтуудыг мөрдөж ажиллах.

1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Захирлын тушаал гарсан боловч цалингийн сан хүрээгүйгээс 4 дүгээр улирлын үр дүнгийн урамшуулалыг тооцож, өр үүсгээгүй.

2. Байгууллагын үндсэн болон туслах үйл ажиллагаа

2.1 Илрүүлэлт:

Тайлант оны 4 дүгээр улирлын цалингийн зардал, түүнтэй холбоотой гарсан тушаал шийдвэрийг тулган шалгахад батлагдсан цалингийн сүлжээний шатлалын дагуу нэмэгдсэн үндсэн цалинг 2,121.6 мянган төгрөгөөр илүү тооцон олгожээ.

Энэ нь үнэн зөв байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна, Засгийн газрын 2018 оны 8 дугаар сарын 22-ны өдрийн 264 дүгээр тогтоолыг зөрчсөн байна.

2.2 Эрсдэл:

- Санхүүгийн үр дүнгийн тайлан буруу илэрхийлэгдсэн байх
- Цалин хөлстэй холбоотой хууль, журам, зааврийг хэрэгжүүлээгүй байх

2.3 Өгсөн зөвлөмж:

Ажиллагсад олгох үндсэн цалин хөлсийг Засгийн газрын 2018 оны 8 дугаар сарын 22-ны өдрийн 264 дүгээр тогтоолын дагуу тооцох.

2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Цалингийн сүлжээний шатлалын хувь хэмжээг нэмэгдүүлэхдээ ажилчдын ажилласан жил, нийгмийн даатгалын дэвтрийг үндэслэж цалингийн шатлалыг тогтоосон. Бичиг хэргийн ажилтан цалин шинэчлэн тогтоосон тушаалын хавсралтыг удаа дараа сольсныг нягталж үзээгүй.

3. Зардлын данстай холбоотой асуудал

3.1 Илрүүлэлт:

Цалингийн тооцооны хүснэгтээрх тооцооллын дүнг ерөнхий журналд бүртгэхдээ цалингийн зардал 1,003.7, нийгмийн даатгалын шимтгэл 155.0, хувь хүний орлогын албан татвар 1,220.2, үйлдвэрчний эвлэлийн суутгал 5.3, гарт олгох цалин 1,031.2, нийт 1,353.1 мянган төгрөгөөр зөрүүтэй бүртгэсэн байна.

Энэ нь иж бүрэн байх, үнэн зөв байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан “Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар журам”-ын 3 дугаар хэсгийн 3.6 тайлангийн хугацааны цалингийн зардлыг бүртгэх тухай заалтыг мөрдөөгүй.

3.2 Эрсдэл:

- Санхүүгийн үр дүнгийн тайлан буруу илэрхийлэгдэх
- Цалин хөлстэй холбоотой хууль, журам, зааврыг хэрэгжүүлээгүй байх

3.3 Өгсөн зөвлөмж:

Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан хавсралт 1 “Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар журам”-ын 3 дугаар хэсгийн 3.6 тайлангийн хугацааны цалингийн зардлыг бүртгэх тухай заалтыг холбогдох хууль, журмын дагуу дансдын бичилтийг үнэн зөв бичиж бүртгэх.

3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Цалингийн тооцооны хүснэгтээрх дүнг санхүүгийн програмд гараас оруулдагаас үүссэн алдаагаа хүлээн зөвшөөрч цаашид анхаарч ажиллах болно.

4. Балансын данстай холбоотой асуудал

4.1 Илрүүлэлт:

Анхан шатны шүүхийн шийдвэрээр тогтоогдсон 688.6 мянган төгрөгийн цалингийн нөхөн олговрыг С.Гэрэлмаад тооцож олгоогүй.

Энэ нь тасалбар болголт, иж бүрэн байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Сүхбаатар дүүргийн Иргэний Хэргийн Анхан Шатны Шүүхийн 2018 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 181/ШШ2018/02523 дугаар шийдвэрийг хэрэгжүүлээгүй байна.

4.2 Эрсдэл:

- Санхүүгийн үр дүнгийн тайлан буруу илэрхийлэгдсэн байх

4.3 Өгсөн зөвлөмж:

Шүүхийн шийдвэрийн дагуу нөхөн олговрыг ажилтанд олгох.

4.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Л.Баярсайхан захирлын үед захирлын тушаал гараагүйгээс олгоогүй. 2019 оны 01 дүгээр сард олгосон.

5. Зардлын данстай холбоотой асуудал

5.1 Илрүүлэлт:

Тайлант оны цалингийн зардлаас 4 дүгээр улирлыг түүвэрлэн авч давтан тооцоолоход Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн хөнгөлөлтийг 10 дугаар сард бүх ажилчдаас адил 16.6 мянган төгрөг, 11,12 дугаар сард зарим ажилчдад илүү, дутуу тооцож нийт 533.3 мянган төгрөгийн хөнгөлөлтийг илүү, 347.1 мянган төгрөгийг татвараас чөлөөлөгдөх ажилчдаас илүү, нийт 880.4 мянган төгрөгийн хувь хүний орлогын албан татварыг илүү суутгасан.

Энэ нь иж бүрэн байх, үнэн зөв байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1, 16 дугаар зүйлийн 16.1.10 заалтыг тус тус зөрчсөн байна.

5.2 Эрсдэл:

- Цалин хөлсийг буруу тооцсон байх
- Цалин хөлстэй холбоотой хууль, журам, зааврыг хэрэгжүүлээгүй байх

5.3 Өгсөн зөвлөмж:

Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн дагуу хөнгөлөлт, чөлөөлөлтийг суутгаж, хууль тогтоомжийн өөрчлөлт, шинэчлэлтийг цаг тухайд нь судалж мөрдөх.

5.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн дагуу чөлөөлөгдөх ажилчид эмнэлгийн хуудсаа бүгд 11 дүгээр сард өгснөөс 10 дугаар сард чөлөөлөлтөнд хамрагдаагүй суутгал хийгдсэн. Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн хөнгөлөлтийг шатлалын дагуу зөв суутгаж цаашид анхаарч ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

4.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Тайлант хугацаа 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>117,746,875.23</u>	<u>118,155,742.84</u>
33	АВЛАГА	-	97,000.00
335	Бусад авлага	-	97,000.00
3351	Байгууллагаас авах авлага	-	97,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	117,746,875.23	118,058,742.84
351	Түүхий эд материал	4,794,276.54	4,494,574.54
35110	Тусгай зориулалттай материал	884,516.54	884,516.54
35130	Эм боох материал	3,909,760.00	3,610,058.00
354	Хангамжийн материал	112,952,598.69	113,564,168.30
35410	Бичиг хэргийн материал	7,062,970.50	9,138,483.98
35420	Аж ахуйн материал	91,130,739.39	93,141,545.39
35440	Түлш, шатах тослох материал	1,336,062.50	1,316,563.85
35450	Барилгын засварын материал	-	1,914,630.00
35460	Хүнсний материал	13,422,826.30	6,428,203.68
35470	Бусад хангамжийн материал	-	1,624,741.40
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>890,213,106.38</u>	<u>2,056,674,168.67</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	890,213,106.38	2,056,674,168.67
392	Биет хөрөнгө	886,653,106.38	2,053,826,168.63
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,921,473,169.00	1,821,494,460.66
39202	Хуримтлагдсан элэгдэл	-1,312,325,534.33	-4,327,500.00
39203	Авто-тээврийн хэрэгсэл	98,458,333.00	98,458,333.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-57,434,027.70	-73,843,749.90
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	534,427,789.57	558,168,728.57
39206	Хуримтлагдсан элэгдэл	-409,383,898.12	-447,510,464.64
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	162,236,752.59	165,236,752.59
39208	Хуримтлагдсан элэгдэл	-83,244,848.17	-96,345,762.19
39214	Бусад үндсэн хөрөнгө	46,187,868.00	-
39215	Хуримтлагдсан элэгдэл	-46,187,868.00	-
39217	Ном	32,445,370.54	32,495,370.54
393	Биет бус хөрөнгө	3,560,000.00	2,848,000.04
39301	Програм хангамж	17,215,837.00	17,215,837.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-13,655,837.00	-14,367,836.96
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,007,959,981.61</u>	<u>2,174,829,911.50</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	<u>1,197,924.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	1,197,924.00
413	Өглөг	-	1,197,924.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	1,197,924.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,007,959,981.61</u>	<u>2,173,631,987.51</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,007,959,981.61	2,173,631,987.51
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	888,053,349.02	888,053,349.02
51101	Өмч: - төрийн	888,053,349.02	888,053,349.02
512	Хуримтлагдсан үр дүн	263,415,178.09	-347,363,294.53
51210	Өмнөх үеийн үр дүн	276,335,271.94	-263,415,178.09
51220	Тайлант үеийн үр дүн	12,920,093.85	-83,948,116.44
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	383,321,810.68	1,632,941,933.02
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,007,959,981.61</u>	<u>2,174,829,911.50</u>

4.2 Аудит хийсэн САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан /төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	917,441,572.78	907,834,839.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	13,120,436.54	26,740,939.00
120	Нийтлэг татварын бус орлого	13,120,436.54	26,740,939.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	13,120,436.54	26,740,939.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	13,120,436.54	26,740,939.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	904,321,136.24	881,093,900.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	857,460,000.00	868,442,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	857,460,000.00	868,442,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	46,861,136.24	12,651,200.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	46,041,136.24	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	820,000.00	12,651,200.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	965,070,313.76	986,112,511.81
21	УРСГАЛ ЗАРДАЛ	965,070,313.76	986,112,511.81
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	906,360,714.41	970,406,336.37
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	597,696,551.84	672,057,733.10
210101	Үндсэн цалин	571,408,273.54	651,621,495.10
210104	Урамшуулал	26,288,278.30	20,436,238.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	65,327,404.81	82,525,054.90
210201	Тэтгэврийн даатгал	41,571,984.77	61,728,451.55
210202	Тэтгэмжийн даатгал	4,751,084.01	4,051,691.11
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,938,853.26	5,300,307.08
210204	Ажилгүйдлийн даатгал	1,187,713.25	1,038,728.72
210205	Эрүүл мэндийн даатгал	11,877,769.52	10,405,876.44
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	42,099,904.00	39,585,340.94
210301	Гэрэл, цахилгаан	11,300,995.38	12,483,681.15
210302	Түлш, халаалт	18,712,069.00	18,650,022.00
210303	Цэвэр, бохир ус	12,086,839.62	8,451,637.79
2104	Хангамж, бараа материалын зардал	20,676,417.30	17,282,567.77
210401	Бичиг хэрэг	10,520,620.00	4,599,885.12
210402	Тээвэр, шатахуун	3,736,008.10	3,547,498.65
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,400,000.00	2,412,000.00
210404	Ном, хэвлэл	310,000.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	654,720.00	1,708,312.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,055,069.20	5,014,872.00
2105	Нормативт зардал	54,844,741.43	47,336,873.24
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,560,742.61	772,722.00
210502	Хоол, хүнс	52,283,998.82	46,564,151.24

Ерөнхий боловсролын 116 дугаар сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,372,700.00	3,315,570.00
210604	Урсгал засвар	9,372,700.00	3,315,570.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,704,420.00	3,263,941.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,392,000.00	3,136,541.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	312,420.00	127,400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	110,638,575.03	105,039,255.42
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	89,700.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,617,000.00	670,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	104,021,575.03	104,279,555.42
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	58,709,599.35	15,706,175.44
2132	Бусад урсгал шилжүүлэг	56,376,600.00	12,505,521.38
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	2,200,000.00	-
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	-	12,505,521.38
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	32,726,600.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	21,450,000.00	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,332,999.35	3,200,654.06
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,332,999.35	3,200,654.06
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>-47,628,740.98</u>	<u>-78,277,672.81</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	5,670,443.63
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	-	5,670,443.63
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	-5,670,443.63
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>-47,628,740.98</u>	<u>-83,948,116.44</u>

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан / төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	917,441,572.78	907,834,839.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	13,120,436.54	26,740,939.00
120	Нийтлэг татварын бус орлого	13,120,436.54	26,740,939.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	13,120,436.54	26,740,939.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	13,120,436.54	26,740,939.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	904,321,136.24	881,093,900.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	857,460,000.00	868,442,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	857,460,000.00	868,442,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	46,861,136.24	12,651,200.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	46,041,136.24	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	820,000.00	12,651,200.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	965,070,313.76	986,112,511.81
21	УРСГАЛ ЗАРДАЛ	965,070,313.76	986,112,511.81
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	906,360,714.41	970,406,336.37
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	597,696,551.84	672,057,733.10
210101	Үндсэн цалин	571,408,273.54	651,621,495.10
210104	Урамшуулал	26,288,278.30	20,436,238.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	65,327,404.81	82,525,054.90
210201	Тэтгэврийн даатгал	41,571,984.77	61,728,451.55
210202	Тэтгэмжийн даатгал	4,751,084.01	4,051,691.11
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,938,853.26	5,300,307.08
210204	Ажилгүйдлийн даатгал	1,187,713.25	1,038,728.72
210205	Эрүүл мэндийн даатгал	11,877,769.52	10,405,876.44
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	42,099,904.00	39,585,340.94
210301	Гэрэл, цахилгаан	11,300,995.38	12,483,681.15
210302	Түлш, халаалт	18,712,069.00	18,650,022.00
210303	Цэвэр, бохир ус	12,086,839.62	8,451,637.79
2104	Хангамж, бараа материалын зардал	20,676,417.30	17,282,567.77
210401	Бичиг хэрэг	10,520,620.00	4,599,885.12
210402	Тээвэр, шатахуун	3,736,008.10	3,547,498.65
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,400,000.00	2,412,000.00
210404	Ном, хэвлэл	310,000.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	654,720.00	1,708,312.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,055,069.20	5,014,872.00
2105	Нормативт зардал	54,844,741.43	47,336,873.24
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,560,742.61	772,722.00
210502	Хоол, хүнс	52,283,998.82	46,564,151.24

Ерөнхий боловсролын 116 дугаар сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,372,700.00	3,315,570.00
210604	Урсгал засвар	9,372,700.00	3,315,570.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,704,420.00	3,263,941.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,392,000.00	3,136,541.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	312,420.00	127,400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	110,638,575.03	105,039,255.42
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	89,700.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,617,000.00	670,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	104,021,575.03	104,279,555.42
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	58,709,599.35	15,706,175.44
2132	Бусад урсгал шилжүүлэг	56,376,600.00	12,505,521.38
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	2,200,000.00	-
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	-	12,505,521.38
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	32,726,600.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	21,450,000.00	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,332,999.35	3,200,654.06
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,332,999.35	3,200,654.06
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>-47,628,740.98</u>	<u>-78,277,672.81</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	5,670,443.63
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	-	5,670,443.63
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	-5,670,443.63
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>-47,628,740.98</u>	<u>-83,948,116.44</u>

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан / төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	888,053,349.02	383,321,810.68	-263,415,178.09	1,007,959,981.61
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	888,053,349.02	383,321,810.68	-263,415,178.09	1,007,959,981.61
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				-
C07	Тайлант үеийн үр дүн				-
C08	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	888,053,349.02	383,321,810.68	-263,415,178.09	1,007,959,981.61
D01	2018 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	888,053,349.02	383,321,810.68	-263,415,178.09	1,007,959,981.61
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	888,053,349.02	383,321,810.68	-263,415,178.09	1,007,959,981.61
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	1,249,620,122.34	-	1,249,620,122.34
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	-83,948,116.44	-83,948,116.44
D09	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	888,053,349.02	1,632,941,933.02	-347,363,294.53	2,173,631,987.51

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан / төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	868,442,700.00	865,243,381.94	3,199,318.06	99.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	868,442,700.00	865,243,381.94		
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	849,044,100.00	845,844,781.94	3,199,318.06	99.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	661,669,500.00	661,669,500.00	-	100.0
210101	Үндсэн цалин	476,423,900.00	476,423,899.50	0.50	100.0
210102	Нэмэгдэл	129,043,100.00	129,043,100.00	-	100.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	741,500.00	-741,500.00	
210104	Урамшуулал	56,202,500.00	55,461,000.50	741,499.50	98.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	79,065,500.00	79,065,500.00	-	100.0
210201	Тэтгэврийн даатгал	54,587,500.00	53,039,738.34	1,547,761.66	97.2
210202	Тэтгэмжийн даатгал	6,119,500.00	4,197,657.00	1,921,843.00	68.6
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,895,600.00	3,205,598.34	1,690,001.66	65.5
210204	Ажилгүйдлийн даатгал	1,223,900.00	2,274,039.67	-1,050,139.67	185.8
210205	Эрүүл мэндийн даатгал	12,239,000.00	16,348,466.65	-4,109,466.65	133.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	42,780,900.00	39,585,340.94	3,195,559.06	92.5
210301	Гэрэл, цахилгаан	13,460,200.00	12,483,681.15	976,518.85	92.7
210302	Түлш, халаалт	21,553,600.00	18,650,022.00	2,903,578.00	86.5
210303	Цэвэр, бохир ус	7,767,100.00	8,451,637.79	-684,537.79	108.8
2104	Хангамж, бараа материалын зардал	13,774,600.00	13,774,600.00	-	100.0
210401	Бичиг хэрэг	4,153,600.00	2,415,192.00	1,738,408.00	58.1
210402	Тээвэр, шатахуун	4,300,000.00	3,097,000.00	1,203,000.00	72.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,200,000.00	2,472,500.00	-272,500.00	112.4
210404	Ном, хэвлэл	350,000.00	93,000.00	257,000.00	26.6
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,020,000.00	1,806,312.00	-786,312.00	177.1
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,751,000.00	3,890,596.00	-2,139,596.00	222.2
2105	Нормативт зардал	36,988,200.00	36,988,200.00	-	100.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	4,015,900.00	3,500,000.00	515,900.00	87.2
210502	Хоол, хүнс	32,122,300.00	32,555,750.00	-433,450.00	101.3
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	850,000.00	932,450.00	-82,450.00	109.7
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,396,400.00	5,396,400.00	-	100.0
210604	Урсгал засвар	5,396,400.00	5,396,400.00	-	100.0

Ерөнхий боловсролын 116 дугаар сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,149,000.00	4,145,241.00	3,759.00	99.9
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,021,600.00	4,017,841.00	3,759.00	99.9
210804	Тээврийн хэрэгслийн татвар	127,400.00	127,400.00	-	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,220,000.00	5,220,000.00	-	100.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,200,000.00	1,200,000.00	-	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,020,000.00	4,020,000.00	-	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	19,398,600.00	19,398,600.00	-	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	19,398,600.00	19,398,600.00	-	100.0
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	19,398,600.00	19,398,600.00	-	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	868,442,700.00	865,243,381.94	3,199,318.06	99.6
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	868,442,700.00	865,243,381.94	3,199,318.06	99.6
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	868,442,700.00	865,243,381.94	3,199,318.06	99.6
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	68.00	75.00		
620001	Удирдах ажилтан	2.00	2.00		
620002	Гүйцэтгэх ажилтан	23.00	23.00		
620003	Үйлчлэх ажилтан	40.00	50.00		
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	121.00	130.00		
630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	121.00	130.00		
630001	Төрийн өмчит ЕБС	121.00	130.00		
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	-	-		

5 Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Ерөнхий боловсролын 116 дугаар сургуулийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2019.02.25			САГ-2019/141/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Ерөнхий боловсролын 116 дугаар сургууль		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллага ас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
1	Цалингийн тооцооны хүснэгтээрх тооцооллын дүн нь ерөнхий журналд цалингийн зардал 1,003.7мянган төгрөгөөр, НДШ-155.0 мянган төгрөг, ХХОАТ 1,220.2 мянган төгрөг, ҮЭ-ийн суутгал 5.3 мянган төгрөг, гарт олгох цалин 1,031.2 мянган төгрөгөөг зөрүүтэй байна.	1,353.1	Зөвлөмж өгөх	Нягтлан бодогч	М.Сарантуяа
2	Анхан шатны шүүхийн шийдвэрээр тогтоогдсон 688.6 мянган төгрөгний С.Гэрэлмаагийн нөхөн олговрыг тооцож олгоогүй байна.	688.6	Зөвлөмж өгөх	Нягтлан бодогч	М.Сарантуяа
3	2018 оны цалингийн зардлаас 4-р улирлыг сонгон шалгахад ХХОАТ-ын хөнгөлөлтийг 10 сард бүх ажилчдад 16.666,66 төгрөгөөр, 11,12 сард хөнгөлөлтийг зарим ажилчдад илүү, дутуу тооцож нийт 533,3 мянган төгрөг, ХХОАТ-ын чөлөөлөгдөх ажилчдаас 347,1 мянган төгрөг, нийт 880,4 мянган төгрөгөөр илүү тооцсон.	880.4	Зөвлөмж өгөх	Нягтлан бодогч	М.Сарантуяа
4	2018 оны төсөвт батлагдсан 4 дүгээр улирлын олгогдоогүй үр дүнгийн урамшуулалыг санхүү байдлын тайланд өр үүсгэж тусгаагүй.	23,428.2	Зөвлөмж өгөх	Нягтлан бодогч	М.Сарантуяа
5	Цалингийн сүлжээний шатлалын хувь хэмжээг нэмэгдүүлэхдээ ажилчдад 2,121.6 мянган төгрөгийг илүү тооцоолсон.	2,121.6	Албан шаардлага	Нягтлан бодогч	М.Сарантуяа
	Дүн	28,471.9			